

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.05.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 04 дүгээр сард 1 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцэж 16 тогтоол баталлаа. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны ажил арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцээд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

2.Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

3.“Хот, хөдөөгийн сэргэлт” бодлогын зорилтыг хангах, Сэлэнгэ аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор “Нээлттэй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийг баталлаа.

4.Сэлэнгэ аймгийн 2023 оны төсөв батлах тухай 82 дугаар тогтоолын хавсралт дахь зарим төсөл арга хэмжээний нэршил өөрчлөх тухай асуудлыг хэлэлцээд уг тогтоолын хоёр, дөрөвдүгээр хавсралтыг хавсралт ёсоор өөрчлөн тогтоов.

5.Ойжуулах, ойн зурвас байгуулах, бургасжуулах талбайн байршлыг батлах тухай асуудлыг хэлэлцээд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойн нөхөн сэргээлт хийж ойжуулах талбайн байршлыг, ойн зурвас байгуулах талбайн байршлыг, голын эрэг орчмын газрыг бургасжуулах талбайн байршлыг тус тус баталлаа.

6.2023 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай асуудлыг сум тус бүрээр хэлэлцэн батлав.

7.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Алтанбулаг сумаас 5, Жавхлант сумаас 5, Зүүнбүрэн сумаас 5, Сант сумаас 3, Цагааннуур сумаас 2, Шаамар сумаас 6, Сүхбаатар сумаас 5, Баруунбүрэн сумаас 5, Орхон сумаас 4, Сайхан сумаас 5, Хүдэр сумаас 5 нийт 50 иргэнийг 2023 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаахаар тогтоолоо.

8.Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламж, автомашин, машин тоног төхөөрөмжийг “Тохилог хараа” ОНӨААТҮГ-т шилжүүлэхийг зөвшөөрөв.

9.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойг 2023 оны 9 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аймгийн төр төсвийн байгууллагын удирдлага, холбогдох алба хаагчдад Үндэсний аюулгүй байдлын талаар суурь ойлголт өгөх сургалтыг зохион байгууллаа.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явц, үр дүн” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, арга хэмжээнд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, дэд сайд М.Ганбаатар, Ойн газрын дарга Б.Оюунсанаа болон албаны хүмүүс оролцлоо.

Зөвлөгөөнөөр аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэхэд гол хөдөлгөгч хүч болсон мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэгчид, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээг байгууллаа. Үүнд:

- “Номгон Форести” ХХК-ий “Монгол орны бореал ойг Сэлэнгэ аймагт нөхөн сэргээх, ойжуулах” төсөл нь ойжуулалт, ойн зурвас байгуулах, голын эрэг орчмыг бургасжуулах ажлыг гүйцэтгэхэд шинэ дэвшилтэд технологи ашиглан дроноор ойжуулах ажлыг Сэлэнгэ аймагт 50000 га талбайд гүйцэтгэж 100 сая мод
- “Болд Төмөр Ерөө гол” ХХК жилд 250.8 га модыг Ерөө, Хүдэр зэрэг сумдын нутагт тарьж, ургуулан 2023-2030 онд 100 сая мод
- “Дархан Төмөрлөг” ТӨХК Сайхан сумын Хараа голын эрэг орчимд бургасжуулах, ойн зурвас байгуулж 300.000 мод
- “Цемент Шохой” ТӨХК жилд 10.000 мод тарьж, 2023-2030 онд 100.000 мод
- Монгол-Солонгосын “Мониторинг үндэсний төв” нь 100 сая мод
- “Бугант Нандин” ХХК нь Ерөө, Хүдэр зэрэг сумдын ойн сангийн хомсдол доройтолд орсон талбайнуудад ойжуулалт хийх, мод үржүүлгийн газруудад тарьц, суулгац ургуулах ажлыг гүйцэтгэн 100 сая мод тарихаар гэрээг үзэглэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд манай аймаг 20,0 сая ширхэг тарьц суулгац тарихаар гэрээ байгуулан “Тарьц, суулгац нийлүүлэгч аймаг” болох эрхэм зорилтыг дэвшүүлсэн бөгөөд амлалтдаа хүрч өнгөрсөн жилээс 3 дахин өсгөж 24,7 сая тарьц суулгац тарьж, ургуулаад байгаа юм.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж УИХ-ын гишүүн Ч.Ундрэм, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO)-ын Монгол дахь Суурин төлөөлөгч Винод Ахужа нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар газар зохион байгуулалт, газрын доройтол, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтийг харгалзан цөлжилт, бэлчээрийн доройтол хамгийн ихээр явагдаж буй Мандал, Ерөө, Жавхлант сумдад газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хамтран боловсруулах ажлын талаар санал солилцлоо.

Зочид НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO)-аас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах /Stream/ төслийн хүрээнд Жавхлант суманд элсний нүүдлийг зогсоож, хөрсний элэгдэл, газрын доройтлыг бууруулах 4.34 га газрыг хамарсан агро-ойн аж ахуйн үйл ажиллагаа болон 60 га хүнсний ногооны талбайг хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах ажлын явцтай танилцлаа. Уг ажлын хүрээнд Жавхлант суманд 6000 мод тариад байгаа юм.

сургуулийн хими, физик, дизайн технологийн хичээлүүдийн 247 нэр төрлийн 19052 ширхэг хэрэглэгдэхүүнийг 33 сургуульд хүлээлгэн өглөө.

Японы Хүүхдийг Ивээх Сангийн зүгээс манай аймагт сургуулийн өмнөх боловсролд тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургалтын орчныг бүрдүүлэхээр төсөл хэрэгжүүлэх зорилгоор судалгааны ажлыг хийж байгаатай холбогдуулан төслийн зохицуулагч Ч.Пүрэв-Очир, аймгийн холбогдох удирдлагууд 6 дугаар цэцэрлэгт ажиллалаа. Тус цэцэрлэг нь 1992 онд Хүүхдийн сувилал хэмээн байгуулагдаж 30 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд сувиллын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2022 оноос хуучин Төмөр замын цэцэрлэгийн байранд орж одоогоор 3 бүлгийн 69 хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол болон эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна.

УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын ивээл дор жил бүр зохион байгуулагддаг “СЭЛЭНГЭ ЛИГ-2023” спортын наадмыг аймгийн иргэдийн дунд эрүүл зөв амьдралын хэв маягийг дэлгэрүүлэх, биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилгоор 10 дахь жилдээ Шатар, Ширээний теннис, Шагайн харваа, Сагсан бөмбөг, Волейбол гэсэн таван спортын төрлөөр зохион байгуулж, 17 сумын 140 баг 1300 гаруй г тамирчид 273 багц медалийн төлөө өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Нийлбэр оноогоор:

- Тэргүүн байрыг Сүхбаатар сум,
- Дэд байрыг Мандал сум,
- Гутгаар байрыг Мандал сумын Хэрх тосгоны баг тамирчид эзэлсэн бол Алтанбулаг, Сайхан, Ерөө, Шаамар, Баянгол, Цагааннуур сумд, Ерөө сумын Бугант тосгон шилдэг сумдаар шалгарлаа.

Монголын хараат бус, хөндлөнгийн чанарын дэд бүтэц төрийн бус байгууллагатай хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад Олон Улсын чанарын стандарт хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийг хангах стратеги төлөвлөлт хийх арга зүйн зөвлөгөө өгч мэргэшүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Стандарт ба хөгжил” 2023-2032 оны Үндэсний бодлого төслийн хүрээнд Монголын хараат бус, хөндлөнгийн чанарын дэд бүтэц төрийн бус байгууллагатай хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад Олон Улсын чанарын стандарт хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийг хангах стратеги төлөвлөлт хийх арга зүйн зөвлөгөө өгч мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль зүйн туслалцааны төв, Ханнс Зайдел сангаас Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн газар, Цэргийн штаб, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрууд ирж өөрийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, иргэдэд зөвлөгөө мэдээллээр үйлчилгээ үзүүллээ.

Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Батлан хамгаалах сайдын 2023 оны дугаар тушаалаар “Оюутан цэрэг” сургалтыг орон нутагт тэр тусмаа манай аймагт анх удаагаа зохион байгуулж байна. Энэ жилийн “Оюутан цэрэг” сургалтад Мандал сумын “Зүүнхараа Политехникийн коллеж”-ийн 10 оюутан хамрагдаж байна.

бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн сорилтын лабораторид сорилт шинжилгээнд хамруулж ажилласан.

Экспорт баталгаажуулалт: Ерөө суманд 2 аж ахуй нэгжийн (“Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс “ХХК) олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 34 удаагийн тээвэрлэлтэд баталгаажуулалт хийж экспортын гэрчилгээ олгосон.

Импортын баталгаажуулалт: Алтанбулаг сумын 1-р багт байрладаг Чөлөөт бүс дотор үйл ажиллагаа явуулдаг “Итирнатитур” ХХК-ий оруулж ирдэг “MNS CAC 87:1996 Шоколад Техникийн шаардлага”, “MNS 0444:1987 Зөөлөн чихэр. Ерөнхий техникийн нөхцөл”, “MNS 0395:1987 Хатуу чихэр. Ерөнхий техникийн нөхцөл” стандартын шаардлагад нийцсэн нэг нэрийн 11 төрлийн чихэр, нэг нэрийн 5 төрлийн жигнэмэгт баталгаажуулалт хийж импортын гэрчилгээ олгосон байна.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 4 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 6 нэрийн 6 стандартын борлуулалт хийж, мөн стандартчилал баталгаажуулалт хэмжил зүйл, сорилтын лабораторийн үйл ажиллагааны талаар 9 мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтын 2023 оны гэрээг 2 байгууллагатай шинээр байгуулаад байна.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Мандал, Баянгол, Ерөө, Хүдэр сумдын 23 ШТС-ын 72 ширхэг шингэн хэмжигч, шинээр ашиглалтад орсон 2 ШТС-ын түгээгүүрийг шалган баталгаажууллаа.

Шалган тохируулгаар: Баянгол, Мандал, Сүхбаатар сумдын 14 термометр шалган тохируулга хийсэн байна.

Массын хэмжлээр: Мандал, Баянгол сум болон Нэгдсэн эмнэлгийн 110 жин баталгаажуулсан байна.

Итгэмжлэгдсэн лаборатори: Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 67 аж ахуй нэгжийн 202 дээжид 1068 үзүүлэлтээр шинжилгээ хийж нийт 1,954,400 төгрөгийг төвлөрүүлсэн.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

4 сард 837 баримтаар 6,2 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 3 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үнд
	Орон нутгийн төсвийн нийт орлого	19,578,560.9	15,796,230.6	80.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	11,790,699.5	13,200,494.7	112.0
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,463,207.2	1,215,005.5	27.2

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 - III	2023 - III	2023 - III 2022 - III
1. ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантариа I зэрэг, кг/	1 500	2 200	146.7
	Талх /орон нутгийн, ш/	1 400	2 000	142.9
	Нарийн боов /кг/	4 300	5 500	127.9
	Будаа /кг/	3 200	3 600	112.5
	Элсэн чихэр /кг/	3 200	3 500	109.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	-	-	-
	Хонины мах /кг/	9 500	9 500	100.0
	Үхрийн мах /кг/	12 000	12 500	104.2
	Адууны мах /кг/	8 500	8 500	100.0
	Ямааны мах /кг/	9 000	8 000	94.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	12 500	18 500	148.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	-	-	-
	Сүү /задгай, л/	2 700	3 700	137.0
	Сүү / савласан, л/	3 800	4 800	126.3
	Тараг /задгай, л/	2 500	-	-
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
	Айраг /л/	5 000	-	-
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	5 500	8 500	154.5
	Өндөг /ш/	400	500	125.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС	-	-	-
	Ургамлын тос /л/	8 100	11 500	142.0
	Өөхөн тос /кг/	3 500	3 000	85.7
	Шар тос /кг/	25 000	25 000	100.0
	Масло /задгай, кг/	6 000	11 000	183.3
5	ХҮНСНИЙ НОГОО	-	-	-
	Төмс /кг/	1 200	1 500	125.0
	Лууван /кг/	2 500	2 000	80.0
	Манжин /кг/	2 500	2 500	100.0
	Байцаа /кг/	2 800	2 500	89.3
	Сонгино /кг/	2 500	3 000	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	6 000	7 500	125.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 000	6 200	155.0
2- ШАТАХУУН		-	-	-
	Бензин А - 80	2 350	2 480	105.5
	Бензин А - 92	2 400	2 500	104.2
	Дизелийн түлш	2 840	3 910	137.7

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл олгох ажлын хүрээнд “Иргэдийн Шударга Шүүх” ТББ-тай хамтран Мандал, Баянгол сумдын нийт

зүйлд заасан үүргээ биелүүлээгүй 3 аж ахуйн нэгжид 3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: “Хуулиа дээдэлж, үүргээ биелүүлэе, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн ирээдүй аян”-ыг үргэлжлүүлэн зохион байгуулж, 4 дүгээр сард 3 хүүхдийн тэтгэлгийг хааж, 22578,8 мянган төгрөгийг тэтгэлэг авагчид олгосон. Мөн “Харилцан хүндэтгэе аян”-ны хүрээнд “Өглөөг мэндчилж угтъя хэсэгчилсэн арга хэмжээ”-г төрийн байгууллагын 34 албан хаагч, 87 иргэнийг хамруулан зохион байгуулсан.

764 төлбөрийн болон хүүхдийн тэтгэлгийн материалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж, төлбөрийн 49 гүйцэтгэх хуудасны 381772.5 мянган төгрөгийн төлбөрийн материал хааж, 378 гүйцэтгэх хуудасны 8.096.0307.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 288 ялтан этгээдэд хяналт тавьж, энэ сард 96 хүний хяналт дуусгавар болж, одоо 192 ялтан этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

Шүүх шинжилгээний хэлтэс: Гэмт хэрэг, зөрчлийн 21 дуудлага дээр хэргийн газарт очиж Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, мөрдөгчийн тогтоолоор 44 удаагийн шүүх эмнэлгийн шинжилгээ хийж, үүнээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 37, цогцост хийх шинжилгээ 7, мөн криминалистикийн 4, тусгай шинжилгээ 4-г хийж, гарын хээний дардас 151, шүүх гэрэл зураг 1534 /үүнээс шинжилгээний 66, хэргийн газрын үзлэгийн 621, цогцсын үзлэг, задлан шинжилгээний 488, бусад 359/-г боловсруулж, мөн галт зэвсгийн сан баяжуулж хонгио 13, хошуу 8-г шинжилгээ хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2023 оны 04 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 150 /эрэгтэй-80, эмэгтэй-70/
 - Гэрлэлтийн бүртгэл - 43
 - Гэрлэлт цуцалсны бүртгэл - 15
 - Үрчлэлт - 4
 - Эцэг, эх тогтоолт - 09 /үүнээс эрэгтэй 5, эмэгтэй 4/
 - Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 12
 - Нас баралт - 56
 - Нийт олгосон иргэний үнэмлэх - 335
 - Шинээр олгосон иргэний үнэмлэх - 107
 - Дахин олгосон иргэний үнэмлэх - 47
 - Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 199
 - Гадаад паспорт олголт - 471
 - Аймаг, хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 141 /үүнээс насанд хүрсэн 93, хүүхэд 48
 - Хот доторх шилжилт хөдөлгөөн - 193 тус тус бүртгэгдсэн байна.
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:**
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 993
 - Анхны бүртгэл - 219
 - Өмчлөх эрх шилжих гэрээ - 197
 - Барьцааны гэрээ - 504

Баянгол, Алтанбулаг, Баруунбүрэн, Түнхэл, Хэрх/ 14 байгууллагын 110 гаруй тамирчид оролцож хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа гарган эрэгтэй эмэгтэй 16 төрлөөр өрсөлдлөө

Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн Ширээний теннисний тэмцээнд 11 сумын 100 гаруй тамирчид ганцаарчилсан, холимог хосын төрөлд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө

“Сэлэнгэ Бодонгууд” клубийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, тэмцээнд 24 багийн 240 гаруй тамирчид оролцлоо.

Аймгийн аварга шалгаруулах Уулын дугуйн тэмцээн зохион байгуулагдаж, тэмцээнд 60 гаруй өсвөрийн тамирчид оролцлоо

Аймгийн аварга шалгаруулах Усанд сэлэлтийн тэмцээн зохион байгуулагдаж, тэмцээнд нийт 30 гаруй тамирчид оролцлоо.

Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, 17 сум, 6 тосгоны 29 багийн 230 гаруй харваачид Багийн харваа болон Цуваа харвааны төрөлд цэц мэргэн, оюун ухаанаа уралдуулан өрсөлдлөө.

Эрүүл мэндийн талаар: Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дугаар тушаалын дагуу Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд 108,887 иргэн хамрагдахаас 27854 иргэн хамрагдаж, хамралтын хувь 25,6 хувь байна.

“Дэлхийн эмч нарын өдөр”-ийг угтан эрүүл мэндийн салбарт хамт олноо манлайлан ажиллаж буй 19 эмчид талархал илэрхийлэн алдаршуулах аяныг зохион байгуулан ажилласан. Энэ аяныг цаашид үргэлжлүүлэн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг алдаршуулан, талархал илэрхийлэхээр ажиллаж байна.

“Халуун сэтгэл-23” явуулын амбулаторийн үзлэгийг төвөөс алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа Зүүнбүрэн Баянгол сумдыг иргэдэд тус тус эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Үзлэгийн багт Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх Хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сайхан, Ерөө, Сант, Хүдэр сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн сумдын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төвийн ажилчид нийт 80 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр суурин болон явуулын хэлбэрээр ажилласан. Сумын Эрүүл мэндийн төвд суурин баг байрлан иргэдэд 5 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж нийт 984 үзлэг, оношилгоог хийсэн байна. Мөн явуулын 2 баг 750 гаруй км замыг туулан алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 4 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо, элэгний В,С вирус илрүүлэх, сахар илрүүлэх шинжилгээ)-г нийт 566 иргэнд үзүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 65621 иргэнд 20938900.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 194 иргэнд 34472.0 мянган төгрөгийг олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүлж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB программд баяжилт хийж ажил олгогчийн мэдээлэл 78, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 109, идэвхтэй ажил

дэмжсэн орчин бүрдүүлэх, нийгэмд эерэг хандлага төлөвшүүлэх санал санаачилгыг дэмжих үүднээс "Хайрлая хамгаалъя" уриан дор Ерөө сумын Бугант тосгонд "Хүүхэд "Гэр бүлийн өдөрлөг" арга хэмжээг Сүхбаатар, Шаамар сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эх асран хамгаалагчдын дунд зохион байгуулж нийт 350 эцэг, эх хамрагдлаа.

Алтанбулаг, Мандал сум дахь Түр хамгаалах байранд үл хайхрах, сэтгэл санааны, бие махбодын хүчирхийлэлд өртсөн, 0-10 насны 5, 11-14 насны 2, насанд хүрэгч 2 эмэгтэй нийт 8 иргэнд 20 хоног аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ, 6 иргэдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүйн тест авч ажилласан.

Шүүхийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 1 өрхийн 2 насанд хүрэгч, 2 хүүхдээс "шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох нэгдсэн арга зүйн гарын авлага" сэтгэл зүйн 14 багц оношилгооны тестийг авч, нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилласан.

Аймгийн залуучуудын хөгжлийн зөвлөлийн "Анхдугаар чуулган"-ыг зохион байгуулж, 17 сум 6 тосгоны төлөөлөл 250 залуучууд оролцож зөвлөлийн дүрэм болон жилийн ажлын төлөвлөгөө баталж, сум орон нутагтаа тулгамдаж буй асуудлын талаар санал солилцлоо.

Эерэг хандлага сургалтыг 6 төрийн байгууллагын 120 албан хаагчдад зохион байгуулж эерэг хандлагыг түгээж ажиллалаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн Тариаланчдын зөвлөгөөнийг хаврын тариалалтын босгон дээр "Хүнсний хангамж-Шинэ сэргэлт" уриатай зохион байгуулж төрөөс баримталж буй бодлого шийдвэр, тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, үр тарианы үйлдвэрлэл эрхлэх таатай боломж, нөхцөл, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх талаар хэлэлцэж, зөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ болон аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, салбарын эрдэмтэн судлаачид, үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид нийт 250 хүн оролцлоо.

"Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн"-ийг аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, 17 сум 6 тосгоны 200 төлөөлөгч оролцуулан 2023 онд төмс, хүнс ногоо, жимс жимсгэнийн тариалан эрхлэгчдийн талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэр, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэх таатай боломж, нөхцөл, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх боломжийг хэлэлцэн амжилттай болж өндөрлөлөө.

Монгол улсад Мал үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын мал зүйч үржүүлэгчдийн холбоо, "Газар Агро" ХХК, "Гацуурт" ХХК хамтран "Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 14 аймаг, нийслэлээс махны үхэр үржүүлж байгаа, цаашид махны үхрийн аж ахуй эрхлэх сонирхолтой иргэн, аж ахуй нэгж, байгууллагын 480 гаруй хүний төлөөлөл оролцуулан фермерийн аж ахуй эрхлэхэд тулгамдаж буй асуудал, экспортын өнөөгийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал, экспортыг нэмэгдүүлэх гарц шийдлүүдийн талаар ярилцаж, санал бодлоо солилцож, гарц шийдлээ илэрхийллээ.

Мал эмнэлгийн Ерөнхий газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын баг, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, Монгол Улсын зөвлөх малын эмч, мал эмнэлгийн шинжлэх ухааны доктор, профессорууд болон 17 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд зэрэг нийт 124 төлөөлөгчид оролцлоо.

Мал эмнэлгийн салбарын 100 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотноо Мал эмнэлгийн Ерөнхий газар, Мал эмнэлгийн үндэсний холбоотой хамтран “Мал эмнэлэг 100” цомын аварга шалгаруулах тэмцээнд 14 сумын нийт 23 малын эмч, мэргэжилтнүүд амжилттай оролцлоо.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/165 дугаар захирамж, “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/214 дүгээр захирамжийн дагуу гахайн сонгомол мялзангаас урьдчилан сэргийлэх тарилгад 12.0 мянган толгой амьтан хамруулахаас 4.6 мянган амьтан хамруулж 38.3 хувьтай, цусан халдвартаас урьдчилан сэргийлэх тарилгад 43.0 мянган толгой үхэр хамруулахаас 1.4 мянган толгой хамруулж 3.3 хувьтай, шөвөг яр 460.0 мянган бог хамруулахаас 66.7 мянган бог хамрагдаж 14.5 хувьтай, дотрын халдварт хордлогын тарилгад 91.0 мянган толгой бог хамруулахаас 32.4 мянган бог хамрагдаж 35.6 хувийн тус тус гүйцэтгэлтэй технологит хугацаанд үргэлжилж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж буй мах махан бүтээгдэхүүний 3960 кг үхрийн махны 33 дээж, 180 кг адууны 2 дээж, 588 кг хонины махны 28 дээж, 120 кг ямааны махны 6 дээж, 54 кг гахайны махны 6 дээж, 675кг сүү, сүүн бүтээгдэхүүний 8 дээж, 40 кг дайвар бүтээгдэхүүний 2 дээж, 100 ширхэг үхрийн ширний 1 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийсэн.

Жавхлант сумаас 15 эмгэгт дээжид нян судлалын шинжилгээг хийж, Зүүнбүрэн, Сүхбаатар, Ерөө, Сант сумын 275 дээжид ийлдэс судлалын шинжилгээг хийхэд Зүүнбүрэн сумын 1 адууны дээжид нийлүүлэг өвчний эсрэг биет, Сүхбаатар сумын 1 адууны дээжид Адууны халдвар цус багадах өвчний эсрэг биет илэрч хариуг баталгаажуулан олгосон.

Сүхбаатар, Зүүнбүрэн, Ерөө, Алтанбулаг сумын 230 дээжид шимэгч судлалын шинжилгээ, Преми-тестийг ашиглан антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг хүнс болон тэжээлд антибиотикийн үлдэгдлийг илрүүлэх арга MNS 6665:2017 стандартын дагуу 13 сорьц дээж цуглуулан Ampicillin, Penicillin, Chloramphenicol, бүлгийн антибиотик байгааг илрүүлэх шинжилгээг хийж, уг бүлгийн антибиотикүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага буюу сөрөг дүнтэй байгааг тогтоосон.

Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн удирдамжийн дагуу санамсаргүй түүврийн аргаар 17 сумын 30 өрхийг хамруулан 480 сорьц дээжийг цуглуулж, программд бүртгэн сорилт шинжилгээний ажил хийгдэж байна.

Мал эмнэлгийн лабораторийн цахим систем www.vetlab.shinjilgee.mn/-д 30 хандалтын 100 сорьц дээжийг бүртгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг сурталчлах, иргэдийн бизнесийг дэмжих, үндэсний болон

тулгах, шалгах, нөхөн оруулах, засварлах ажлыг зохион байгуулж, сумдын газрын даамлуудыг арга зүйн зөвлөмж чиглэлээр ханган ажиллаж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчилд “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” явуулж нийт 9 иргэний зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, эзэмшил газрын хэмжээ байршлыг дур мэдэн ихэсгэсэн 8 иргэн, эзэмших эрхийн хугацааг сунгуулах хүсэлтийг хэтрүүлж хүсэлт гаргасан 1 иргэнд тус тус торгууль оногдуулж, 100 хувь төлбөрийг барагдуулсан.

Хяналт шалгалтын ажлын чиглэлээр: Зам тээврийн хөгжлийн яамны салбарын ерөнхий байцаагчийн 2023 оны 04/20 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу хүсэлт ирүүлсэн 1 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, Баянгол уурхайд аюултай ачаа тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглагдаж буй 2 тээврийн хэрэгсэлд улсын байцаагчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

Аймгийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцож байгаа ачааны автомашины ачаа тээвэрлэлт, зам, замын байгууламжийн ашиглалт, Автотээврийн тухай, Автозамын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020 стандартын шаардлага хангаагүй зөрчлийг таслан зогсоох хяналт шалгалтыг “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК, Тээврийн Цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдалд хуулийн дагуу арга хэмжээ тооцох, зөрчлийг арилгахад хяналт тавин даац хэтрүүлэн тээвэрлэлт гүйцэтгэж байсан том оврын 5 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан 1 аж ахуйн нэгж, 1 иргэд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/05, 02-00/06, 02-00/07 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Сүхбаатар, Мандал суманд Барилгын техникийн хяналтын улсын байцаагчтай хамтарсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг тооцон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт үргэлжилж байна.

Зургаа. Сүм орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхлэх таатай боломж нөхцөлийг хэлэлцэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн эрчимжүүлэх, эрүүлжүүлэх, малчдад мал аж ахуйн талаар баримтлах бодлого, зорилтыг танилцуулах, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах зорилготой Алтанбулаг сумын “Малчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дарга П.Сарангэрэл, сумын Засаг дарга Н.Отгонцогт, “Хүчү агро” ХХК-ий захирал С.Барцадгүй, зөвлөх мал зүйч доктор Д.Бямбаа, “Мимо” ХХК-ий арга зүйч, сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтнүүд оролцож тулгамдсан асуудлын талаар ярилцаж заавар зөвлөмж өгч иргэдтэй санал бодлоо солилцлоо.

Арга хэмжээний үеэр ажил, үйлс, хөдөлмөр бүтээлээ үнэлүүлсэн малчдаа шагнаж урамшууллаа.

тонн улаанбуудайн үр шаардлагатай мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Хаврын чийг хаалтыг 8 аж ахуй нэгж, иргэн 7400 га талбайд хийгээд байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн төслийн сонгон шалгаруулалтад 3 нөхөрлөл, 2 ХХК, 6 иргэний нийт 11 төсөл ирүүлснээс төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдаанаар 4 төсөл шалгарч гэрээ байгуулах шатанд явагдаж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газраас хуваарлигдсан мал, амьтны гоц халдварт Шүлхий /A01/ өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд 3 ажлын хэсэг ажиллаж нийт 145 өрхийн 8000 толгой үхэрт хүйтэн хэлхээний горимыг баримтлан хийж гүйцэтгээд байна.

Санамсаргүй сонгогдсон 2 малчин өрхөөс мал, амьтны гоц халдварт Шүлхий /A01/ өвчний тандалт судалгааг 8 толгой үхэр, 16 толгой бог малаас цусны дээжийг авч аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид хүргүүлэн, мэдээллийг тандалтыг цахим системд шивээд байна.

Ерөнхий боловсролын сургууль, “Мобиком” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хичээл сургалтын үед ухаалаг утаснаас татгалзах, шаардлагатай тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчтайгаа холбогдох бүх сүлжээнд үнэгүй ярих “Итгэлтэй утас”-ыг сургуулийн төв зааланд байрлуулан ажиллуулж эхэллээ.

Сумын хамтарсан баг нь эрсдэлт нөхцөлд байгаа 5 өрхийн 11 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ, хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийж материалыг холбогдох газарт нь хүргүүллээ. Мөн Сайхан сум дахь Цагдаагийн хэсэгтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрөл, хүрээлэн буй орчин, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, архины хамааралтай 4 өрхөөр орж нөхцөл байдалтай танилцан, сумын төвд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийж, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Булган аймагт зохион байгуулагдсан Булган аймгийн Засаг даргын нэрэмжит “БУГАТ ЦОМ-2023” Олон хотын аварга шалгаруулах боксын тэмцээнд тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн Биений тамирын багш Б.Эрдэнэтунгалагийн бэлтгэсэн гурван сурагч оролцож 8а ангийн сурагч н.Отгончимэг мөнгөн медаль, н.Анхчимэг хүрэл медаль тус тус хүртлээ.

Аймгийн аварга шалгаруулах “Хөнгөн атлетик”-ийн тэмцээнд сурагч н.Анхчимэг 3000 метрийн гүйлтээр Хүрэл медаль, н.Отгончимэг 200 метрийн гүйлтээр Мөнгөн медаль, “Ширээний теннис”-ний 9-10 насны ангилалд сурагч Ц.Магнайбаяр Мөнгөн медаль тус тус хүртлээ.

Тус сард Орхон бүсийн сум дундын ойн анги нь 127 м3 модны гарал үүслийн гэрчилгээ бичиж, Сант сумын Ойн мэргэжлийн байгууллага “Шинэ Орос хийц” ХХК-ий мод бэлтгэлийн үйл явц, тээвэрлэлтэд хяналт шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Баянгол сум:

Тариаланчдын Улсын зөвлөгөөнд газар тариалангийн салбарын 8 аж ахуй нэгж, иргэдийн төлөөлөл, аймгийн “Тариаланчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 8 аж ахуй нэгжийн төлөөлөл, аймгийн “Ногоочдын зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 11 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл тус тус оролцлоо.

MNS5390:2004) цахилгаан байгууламжийн дүрмийг танилцуулан сумын гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийж, үнэллээ.

Малын удмын санг сайжруулах зорилгоор Европын Холбооны санхүүжилттэй Нэгдсэн Үндэсний байгууллагын ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн менежмент, эко системийн тогтвортой байдлыг хангах” (Stream) төслөөс үржлийн нэгжид 80 сая төгрөгийн 17 нэр төрлийн тоног төхөөрөмжийг Нэгдсэн Үндэсний байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Винод Ахужа, УИХ-ын гишүүн Ч.Ундрам, УИХ-ын Байгаль орчин ХАА-ын байнгын хорооны дарга УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Стрийм төслийн менежер А.Амгалан нар гардуулан өглөө.

2023 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 23222 толгой мал төллөсөн (Гүү 250, Үнээ 3520, Хонь 11200, Ямаа 9102) ба мал төллөлт 70.6 хувьтай явагдаж байна.

НҮБ-ын хөрөнгө оруулалтаар мал үржлийн нэгжийн үйл ажиллагаанд 80 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг нийлүүлээд байна.

Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр гүний худаг, малын удмын сан сайжруулах гүү, бух худалдаж авах болон мал угаалгын банн, мал тарилгын төмөр хашаа барих, Тавин багийн 3 хэсэгт гүүр барих зэрэг ажлын тендерийг зарлалаа.

Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сумын хэмжээнд 108 өрхийн 19000 толгой богийн төл малыг вакцинд хамруулахаас 25 өрхийн 5167 толгой төл малд вакцин хийгдсэн.

Түүврийн аргаар сонгогдсон сумын 3 дугаар багийн малчин В.Буянтогтохын 4 толгой үхэр, 6 толгой хонь, 6 толгой ямаа нийт 16 толгой малаас дээж авлаа.

Жавхлант сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар сумын малчин К.Амангельд, Ж.Жапар нарыг Төрийн дээд “Алтангадас” одонгоор шагнагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 тоот тогтоол, Биеийн Тамир, Спортын улсын хорооны 2022 оны А/26 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3 дахь заалтыг хэрэгжүүлэх, иргэдийн дунд биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдрын чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын төр, төсвийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хооронд сумын Засаг даргын ивээл дор таван төрөлт тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/154 дүгээр захирамжийн дагуу Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Г.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг тус суманд болзошгүй гамшгийн аюул, хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг сургах, харилцан ажиллагааг сайжруулах, 2023 оны 5 дугаар сард зохион байгуулагдах стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

“Хоггүй Жавхлант аян”-ны хүрээнд төр, төсвийн байгууллагууд сумын төвийн ногоон байгууламжийн зүүн хойд талын хэсэг болон наадмын талбайн өмнөх ногоон байгууламж, сумын төвийн доторх замын суваг шуудуу болон сумын төвөөс олон улсын зам хүртэлх 7.3 км замын суваг шуудуу болон зам дагуух газрын хог хаягдлыг цэвэрлэлээ. Мөн сумын төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэж түрэх ажлыг “Төхөм тал ургац” нөхөрлөлийн хамт олонтой хамтран хийж гүйцэтгэлээ.

Зүүнхараа сангийн аж ахуй үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан Хэрх Захирагчийн албаны нэрэмжит шилжин явах “Захирагчийн цом” залуучуудын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 8 баг эмэгтэй 8 баг нийт 16 багийн 130 тамирчин оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорилоо.

Мод бэлтгэх гэрээг үндэслэн 7 аж ахуй нэгж байгууллагад 800,2 м3 хэрэглээ, 269 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгож 5,1 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Мөн 15 аж ахуй нэгж байгууллагад 672 м3 хэрэглээ, 111м3 түлээний модонд тус тус гарал үүслийн гэрчилгээг олголоо.

Сумын Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулах тухай” А/96 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 94 нөхөрлөл, аж ахуй нэгж, албан байгууллагуудад хүргүүлэн, ойн санг гэрээгээр эзэмшдэг 23 мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагатай хурал хийж, хуурайшилтын үеийн хариуцлагын гэрээ байгууллаа. Мөн хуурайшилттай холбоотойгоор Засаг даргын тамгын газарт хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган 23 аж ахуй нэгж байгууллагын төлөөллийг ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Хяналтын цэгт ажиллуулах тухай” А/153 дугаар захирамжийн хүрээнд Аргахайт, Барчулуутын нэгдсэн постод Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтсийн албан хаагчид, Түнхэл дэх Хужиртын нэгдсэн постод мод бэлтгэлийн 10 мэргэжлийн байгууллагууд хуваарийн дагуу тус тус ажиллаж байна.

Түнхэл тосгоны 10 мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагуудад Улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн, Мандал сумын Засаг даргын “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн биелэлтэд хяналт тавих шалгалтын удирдамж боловсруулан нэгдсэн постуудад хяналт шалгалт хийж ойн бүхий газарт нутаглаж буй малчин өрхүүдэд урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч 37 өрхтэй хуурайшилтын хариуцлагын гэрээ байгууллаа.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Жимс жимсгэнийн аж ахуй эрхлэх” сургалтыг сумын иргэдэд “Булгал голын алим” ХХК-ий захирал Х.Балжинням, менежер Б.Эрдэнэбаяр, “Монгол Алтайн алтан алим” ХХК-ий захирал С.Ариунбаатар нарыг урьж оролцуулан зохион байгууллаа. Сургалтаар

- Жимс, жимсгэнийн аж ахуй эрхлэх түүний ач холбогдол, эдийн засгийн үр ашиг,
- Чавга, Интоор, Лийр, Алимны мод тарихад анхаарах асуудал
- Жимсний модыг залгалт хийж үржүүлэх арга технологи
- 3 өрхийн тарьсан жимсний модонд таналт тайралт хийх дадлага зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийж 116 иргэдийг хамрууллаа.

“Малчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээг Баянгол, Сант, Алтанбулаг сумдын болон тус сумын нийт 280 гаруй малчин болон мал бүхий өрхийн дунд зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр малын үүлдэр угсааг сайжруулж, ашиг шим өндөртэй эрчимжсэн мал, амьтныг хөгжүүлэх зорилгоор “Шилмэл малын үзэсгэлэн” зохион байгуулаа. Үзэсгэлэнд 9 багийн цэвэр үүлдрийн азарга, мах сүүний чиглэлийн үнээ болон малын хөлийн албан татвараар багуудад тараагдсан бух нийт 20 гаруй малыг оролцуулж харилцан туршлага судлууллаа.

Улс, аймгийн “Тариаланчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 22 ногоочдыг оролцуулсан.

Сумын Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх тухай” А/23 тоот захирамжийн хүрээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай 104 мэдэгдлийг малчин, мал бүхий айл өрхүүдэд тараан гарын үсгээр баталгаажуулж ажиллалаа.

Хаврын оготно устгалын ажилтай холбогдуулан малчдад малаа хариулга маллагаатай байлгах тариалангийн талбайд малаа бэлчээхгүй байх албан мэдэгдлийг 45 айл өрхөд хүргэн ажилласан.

Орхонтуул сум:

Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд хэрхэн хүргэж байгаад хяналт шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгах, төр төсвийн байгууллагуудыг дээшлүүлэх тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн хөгжил дэвшлийн талаарх шинэ сайн ойлголт, санал санаачилгыг дэмжих, дэлгэрүүлэх зорилгоор Засаг даргын А/51 дүгээр захирамжаар, Засаг даргын нэрэмжит үзлэгийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/154 дүгээр захирамжаар томилогдсон Онцгой байдлын газрын ажлын хэсэг хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийж, сургалт зохион байгуулж, улсын хэмжээнд стратегийн команд штабын сургууль ирэх 5 дугаар сард зохион байгуулагдахтай холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд сумын төв болон Рашаант тосгонд ажиллалаа. Тус ажлын хэсэг болзошгүй гамшгийн аюул, хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг шалган заавар, зөвлөмж өглөө.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, аймгийн Засаг даргын 2023 оны А/179 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын 2023 оны А/59 тоот захирамжаар 2023 оны Нэгдүгээр ээлжийн цэргийн албаны татлагыг Сайхан суманд зохион байгуулж сумын хэмжээнд нийт 23 иргэн хамрагдсан байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зарласан Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих, Баянцогт 2-р багт Хогийн машин худалдан авах, Рашаант тосгонд Хогийн машин худалдан авах ажлын тендер нээсэн байна. Сумын Эрүүл мэндийн төвд шинжилгээний тоног төхөөрөмж худалдан авах, Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвд түргэний машин худалдан авах ажлууд 100 хувь хийгдсэн байна.

Сайхан сум:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлан зохион байгуулагддаг “Архигүй, Тамхигүй, Авлигагүй-2023” тэмцээнийг төр, төсвийн 13 байгууллагын дунд сагсан бөмбөг /эрэгтэй/, волейбол /эмэгтэй/, ажлын байрны дасгал зэрэг төрлүүдээр зохион байгууллаа.

Сум дундын Цагдаагийн хэлтсээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “АНЗААР” аяныг зохион байгуулагдлаа. Тус сургалтад ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчид,

нийт 12 хүн, Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн төвийн бүсийн нэгдсэн зөвлөгөөнд сумын Засаг дарга 4 малчин оролцлоо.

Сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлт, хүнсний хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Хяналт шалгалтын явцад илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулах талаар байгууллагын удирдлагуудад шаардлага тавьж ажиллаж байна.

Сүхбаатар сум:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад тавих санал, хүсэлтийг сонсох зорилготой “Иргэдээ сонсьё” арга хэмжээг 8 багийн иргэдийн дунд зохион байгууллаа. Арга хэмжээнд 8 багийн 500 гаруй иргэн оролцож хөрөнгө оруулалтын ажлуудтай танилцаж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар мэдээлэл авлаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, “И Монголиа академи”, Насан туршийн боловсролын төвтэй хамтран сумын ахмадуудад “И Монголиа”-д бүртгэл үүсгэх, ухаалаг утасны тохиргоо сэдэвт сургалтыг зохион байгуулж, 40 гаруй ахмадууд хамрагдлаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хөвгүүдэд эх орноо хамгаалах үзэл төлөвшүүлэх, эр цэргийн албаны тухай мэдлэг олгох, цэргийн алба хаасан 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд алдаршуулах зорилгоор “Эр зоригийн түүх” уулзалт, арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, дэд хурандаа Б.Мөнгөнцоож, 3 жилийн хугацаат цэргийн алба хаасан Боргүвээ 5 дугаар багийн ахмад настан, дэд хурандаа Ж.Чулуун, Ганзам 7 дугаар багийн иргэн, багийн Засаг дарга Б.Ганбат, 1 жилийн хугацаат цэргийн алба хаасан Боргүвээ 5 дугаар багийн иргэн О.Элбэгсайхан нар урилгаар оролцлоо.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж 8 багийн 80 иргэн оролцлоо.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран 8 багийн иргэдийн дунд “Кибер гэмт хэргийн ойлголт, кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 35 сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчид оролцсон төрөлжсөн хичээлийн олимпиадад тус сумын 7 сургуулийн 20 сурагч оролцсон төрөлдөө түрүүлэн улсын олимпиадад оролцох эрхээ авсан. Мөн багш нарын төрөлд 6 багш түрүүлэн улсын уралдаанд оролцохоор бэлтгэж байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын “Чадварлаг багш-2023” сайн хичээл, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг ажил, арга хэмжээнд 1,2,3,4,5,6,7,8 дугаар цэцэрлэгийн багш нар мэргэжил, арга зүй, ур чадвараа бусадтайгаа хуваалцлаа.

“Мэргэжил сонголт-2023” арга хэмжээний хүрээнд Олон Улсын Улаанбаатар их сургуулийн эрдэмтэн профессорууд ирж “Солонгост суралцах боломж давуу тал”, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ” сэдвээр ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад илтгэл тавин ярилцаж Солонгос Улсын хэл соёлтой танилцах арга хэмжээг зохион байгууллаа.

- 3-р байр Б.Бадамжаргал нар тус тус байр эзэллээ.

Улсын тариаланчдын зөвлөгөөнд 6 аж ахуйн нэгж, тариаланч, аймгийн тариаланчдын зөвлөгөөнд 10 аж ахуйн нэгж, тариаланч, аймгийн ногоочдын зөвлөгөөнд 15 ногоочин иргэдийг тус тус хамрууллаа.

“ВИ ТИ НИТ”-ийн төслийн багш Daniel Mora удирдан явуулсан Facilitation буюу Чиглүүлэгч сургалтад нийт 23 багш, ахлах ангийн 30 сурагч, 5-р ангийн 32 сурагчид хамрагдлаа.

“Номын баяр 2023” сарын аяны хүрээнд зохион явуулсан “Үлгэрийн ертөнцөөр аялсан нь” дүрийн тоглолтод 2-12-р ангийн сурагчид оролцлоо.

Хүдэр сум:

Сумын хэмжээнд 8661 мөл төллөж төлөлт 46 хувьтай байна. Үүнийг төрлөөр ангилвал унага 424, тугал 1984, хурга 3403, ишиг 2850 төл мал бойжиж байна. Сумын хэмжээнд том малын хорогдол 73 гарсан байна.

Аймгийн ногоочид, тариаланчдын зөвлөгөөнд 22 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.

Тайлант сард 26 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: Үхэр 5 толгой, адууны мах 1020 кг, үхрийн мах 800 кг, нийт 11820 кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавин ажиллалаа.

Эрт илрүүлэг үзлэгийн идэвхгүй тандалтын мэдээллийг Мал эмнэлгийн нэгдсэн системд шивэлт хийж оруулах ажилд нийт 10 өрхийн суурьт 2000 үхэр хонь 250, ямаа 170 нийт 2420 толгойд мал сүрэгт түүвэрчлэн үзлэг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2023 оны “Мал амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний ийлдэс судлал, эмнэл зүйн тандалт хийх тухай” удирдамжийн дагуу мал амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний тархалтын хувь тогтоох тандалт шинжилгээний ажлыг зохион байгууллаа.

Тархвар зүйн “Санамсаргүй түүврийн” аргад суурилсан ийлдэс судлал болон эмнэл зүйн идэвхтэй тандалтыг явуулахад, санамсаргүй сонгогдсон 1 малчин өрхийн үхэр 4 толгой, хонь 6 толгой, ямаа 6 толгой малаас нийт 16 цус авч аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид илгээж ажиллалаа.

Сумын Хүүхэд гэр бүл хамгааллын хамтарсан багаас зохион байгуулсан “Би хамгаалагдах эрхтэй” илтгэлийн уралдаанд Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдын төлөөлөл 9 баг оролцлоо. 1-р байранд 11а ангийн сурагч М.Оюунзаяа, Б.Болортуяа, 2-р байранд 10а ангийн сурагч Б.Хишигбуян, С.Марал-Од, 3-р байранд 11а ангийн сурагчид М.Мөнхжаргал, Г.Маралжин нарын илтгэл

Цагааннуур сум:

“Шүүхийн нээлттэй байдал, иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ өдөрлөг”-ийг аймгийн Шүүхийн Тамгын газраас зохион байгуулж, сургалтад сумын төр, төсвийн 6 байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн 45 ажилтан, албан хаагчид хамрагдаж, шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгох, сонгогдох, эвлэрүүлэн зуучлалын давуу тал, захиргаа, эрүү, иргэний шүүхэд мэдүүлэх эрхийн талаар мэдээлэл, зөвлөгөө авсан.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Тариалангийн сэргэлт-2023” улсын тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнд сумын газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 10 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулсан.